



МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙДЫН ТУШААЛ

2019 оны 12 сарын 25 өдөр

Дугаар А/239

Улаанбаатар хот

Журамд нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын хилийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.8 дахь хэсэг, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/295 дугаар тушаалаар батлагдсан "Монгол Улсын хилээр нэвтэрч байгаа зорчигч, тээврийн хэрэгслийн нэгдсэн санг ашиглах, мэдээлэл харилцан солилцох журам"-д дор дурдсан нэмэлт, өөрчлөлт оруулсугай:

1.1.Журмын "Гурав"-т "3.2.4.Монгол Улсын харьяат болох, иргэний харьяаллыг сэргээн тогтоох, харьяатаас гарах иргэний бүртгэлийн;" гэж, "3.3.3. гадаад улсын эрх бүхий байгууллагаас өөрийн улсын иргэний хил нэвтрэх баримт бичгийг хүчингүйд тооцсон албан ёсны мэдээлэл" гэж, "3.4.5.тухайн орны эрх бүхий байгууллагаас бичиг баримтыг нь хүчингүйд тооцсоныг албан ёсоор мэдэгдсэн гадаадын иргэний мэдээлэл;" гэж, "Дөрөв"-т "4.2.Хэсэгчилсэн хуулбар мэдээллийн сангийн серверийн байгууламж, цахилгаан хангамж, холболтын техник хэрэгслүүдийг Гадаадын иргэн, харьяатын газарт тусгайлан бэлтгэсэн өрөө, зогсуурт байршуулах ба цахилгаан хангамж нь хоёр талын тэжээлтэй, нөөц цахилгаан үүсгүүртэй байна." гэж, "Тав"-д "5.6.Төрийн байгууллагууд цахим системийн нэгдсэн сангаас дор дурдсан журмаар мэдээлэл өгнө:

5.6.1.мэдээллийг төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээгээр дамжуулан, хуулбар мэдээллийн сангаас шаардлагатай мэдээллийг өгөх бөгөөд энэхүү асуудлыг Хил хамгаалах ерөнхий газар хариуцна;

5.6.2.журмын 3.3 дахь хэсэгт хамаарах мэдээллийг авах хүсэлтээ Тагнуулын ерөнхий газрын зөвшөөрлийн хамт Хил хамгаалах ерөнхий газарт бичгээр гаргана;

5.6.3.журмын 3.4 дэх хэсэгт хамаарах мэдээллийг авах хүсэлтээ Гадаадын иргэн, харьяатын газрын болон Тагнуулын ерөнхий газрын зөвшөөрлийн хамт Хил хамгаалах ерөнхий газарт бичгээр гаргана;

5.6.4.Хил хамгаалах ерөнхий газар нь журмын 5.6.2, 5.6.3-т заасан зөвшөөрлийг үндэслэн цахим системд холбогдох хүсэлтийг судлан үзэж, газрын дарга шийдвэр гаргах бөгөөд уг шийдвэрийг албан бичгээр хүргүүлнэ;

151601015

5.6.5.Хил хамгаалах ерөнхий газар энэ журмын 5.6.4-т заасан шийдвэрийн дагуу тухайн эрх бүхий төрийн байгууллагатай гэрээ байгуулж, нэвтрэх эрхийг олгоно;

5.6.6.Хил хамгаалах ерөнхий газар энэ журмын 5.6.1-д заасан мэдээлэл өгөхөд хяналт тавих бөгөөд албаны бус зориулалтаар ашигласан тохиолдолд гэрээг цуцлах шийдвэрийг газрын дарга гаргана.” гэж, “Зургаа”-д “6.1.6.цахим системийн аюулгүй байдлыг хангах талаар зохион байгуулалт, техникийн арга хэмжээг хамтран шуурхай авч хэрэгжүүлэх;” гэж, “6.1.7.Тагнуулын ерөнхий газраас тогтоосон шалгуур үзүүлэлтийг хангасан, нууцын баталгаа гаргасан албан тушаалтныг цахим системд нэвтрэх эрх бүхий албан тушаалтнаар томилж ажиллуулах.” гэж, “Найм”-ын 8.1.3-т “сүлжээнд” гэсний дараа “шууд болон давхар” гэж, “Ес”-д “9.2.Дээрх нэгж нь цахим системд холбогдсон эрх бүхий байгууллагуудад цахим мэдээлэл алдагдах, үрэгдэх эрсдэлийг илрүүлэх, таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэргэжил, арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.” гэж тус тус нэмэх.

1.2.Журмын “Хоёр”-ыг дор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Хоёр.Цахим системийн бүтэц, хандах эрхийн зохицуулалт

2.1.Хилийн боомтыг цахим системд дамжуулах байгууламжаар холбож, Хил хамгаалах ерөнхий газарт төвлөрүүлэн ажиллуулна.

2.2.Цахим систем нь дараахь сүлжээ, тоног төхөөрөмж, програм хангамж, мэдээллийн сангаас бүрдэнэ:

2.2.1.хилийн боомтуудыг Хил хамгаалах ерөнхий газартай холбосон үндсэн сүлжээ;

2.2.2.Хил хамгаалах ерөнхий газарт байрлах цахим системийг Гадаадын иргэн, харьяатын газар болон түүний харьяа бүсийн газар, аймгийн төлөөллүүд, ашиглах эрх бүхий байгууллагуудтай холбосон сүлжээ;

2.2.3.серверийн байгууламж, компьютер, техник хэрэгсэл, мэдээллийн аюулгүй байдлын болон цахилгаан хангамжийн тоног төхөөрөмж;

2.2.4.зориулалтын програм хангамж;

2.2.5.Хил хамгаалах ерөнхий газарт байрших цахим мэдээллийн нэгдсэн сан /цаашид “мэдээллийн нэгдсэн сан” гэх/;

2.2.6.Гадаадын иргэн, харьяатын газарт байрших мэдээллийн нэгдсэн сангийн хэсэгчилсэн хуулбар бүхий цахим мэдээллийн сан /цаашид “хэсэгчилсэн хуулбар мэдээллийн сан” гэх/;

2.2.7.Үндэсний дата төвд байрших мэдээллийн нэгдсэн сангийн хуулбар сан /цаашид “хуулбар мэдээллийн сан” гэх/.

2.3.Цахим системийн ерөнхий хариуцагч нь Хил хамгаалах ерөнхий газар байх бөгөөд цахим системийн хэвийн, тасралтгүй ажиллагаа, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг хууль тогтоомжид заасны дагуу Тагнуулын ерөнхий газартай хамтран зохион байгуулна.

2.4.Цахим системийн үндсэн хэрэглэгч болох дараахь байгууллага нь цахим системд холбогдож, зөвхөн өөрийн бүрдүүлсэн мэдээллийн нэгдсэн санд өөрчлөлт, баяжилт, засвар хийх эрхтэй.

2.4.1.Хил хамгаалах ерөнхий газар;

2.4.2.Гадаадын иргэн, харьяатын газар.

2.5.Цахим системд нэвтрэх эрхийг дор дурдсан түвшингээр хэрэгжүүлнэ:

2.5.1.цахим системийн үндсэн тоног төхөөрөмжүүдэд нэвтрэх эрхийг Хил хамгаалах ерөнхий газар хэрэгжүүлнэ;

2.5.2.хэсэгчилсэн хуулбар мэдээллийн сангийн тоног төхөөрөмжүүдэд нэвтрэх эрхийг Гадаадын иргэн, харьяатын газар хэрэгжүүлнэ;

2.5.3.мэдээллийн санд нэвтрэх давуу эрхийг Хил хамгаалах ерөнхий газар хэрэгжүүлэх ба Гадаадын иргэн, харьяатын газар зөвхөн өөрийн бүрдүүлсэн мэдээллийн санд нэвтрэх эрхтэй;

2.5.4.хэсэгчилсэн хуулбар мэдээллийн санд нэвтрэх давуу эрхийг Гадаадын иргэн, харьяатын газар хэрэгжүүлнэ;

2.5.5.хуулбар мэдээллийн санд нэвтрэх давуу эрхийг Хил хамгаалах ерөнхий газар хэрэгжүүлнэ;

2.5.6.зориулалтын програм хангамжаар нэвтрэх хэрэглэгчийн эрхийг үндсэн болон эрх бүхий бусад байгууллагуудын хэрэглэгчид хэрэгжүүлнэ.

2.6.Цахим системийн хэрэглэгчийн програм хангамжаар нэвтрэх эрхийг дараахь журмаар нээж, өөрчилж, цуцална:

2.6.1.цахим системийн үндсэн хэрэглэгчээс эрх бүхий бусад байгууллагуудын хэрэглэгчдэд програм хангамжаар нэвтрэх эрхийг нээх, өөрчлөх, цуцлах асуудлыг өөрсдийн бүрдүүлсэн мэдээллийн хувьд тус тусдаа хариуцна;

2.6.2.эрх бүхий бусад байгууллагын хэрэглэгчдэд нэвтрэх эрхийг нээх, цуцлах асуудлыг хэрэглэгчийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтны бичгээр гаргасан хүсэлт болон Тагнуулын ерөнхий газрын зөвшөөрлийг үндэслэн Хил хамгаалах ерөнхий газар шийдвэрлэнэ;

2.7.Цахим системд зориулалтын програм хангамжаар нэвтрэх эрх бүхий байгууллагууд нь Хил хамгаалах ерөнхий газарт техник хэрэгслийн сүлжээний физик

хаяг, системд ажиллах албан тушаалтны мэдээллийг гаргаж өгнө.

2.8.Байгууллагууд нь цахим системд холбогдохдоо шаардлага хангасан компьютер, тусгай зориулалтын техник хэрэгсэл, албан ёсны эрхтэй програм хангамж ашиглах ба шаардагдах техник хэрэгсэл, харилцан холболтын зардлаа хариуцна.”

1.3.Журмын 3.6-д “Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын” гэснийг “улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын.” гэж, 4.2-ыг “4.3.Мэдээллийн нэгдсэн сангийн хуулбар сангийн төрийн цахим мэдээлэл солилцооны системээр дамжуулан Үндэсний дата төвд байршуулна.” гэж, 5.4-ийг “5.3” гэж, 5.5-ыг “5.4” гэж, 5.6-г “5.5” гэж, 5.4-т “5.3.” гэснийг “5.6.4” гэж, 6.1.1-д “Засгийн газрын 2017 оны 159 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн цахим мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах журам” гэснийг “Засгийн газрын 2019 оны 220 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн байгууллагаас төрийн болон бусад байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл солилцох, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам”” гэж, 9.1-д “Тагнуулын ерөнхий газрын харьяа Төрийн мэдээлэл холбооны газар” гэснийг “Тагнуулын ерөнхий газрын мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий нэгж” гэж тус тус өөрчлөх.

1.4.Журмын 5.3-ыг хасах.

2.Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хил хамгаалах ерөнхий газрын дарга /хошууч генерал Ц.Сэргэлэн/, Гадаадын иргэн, харьяатын газрын дарга /Д.Мөрөн/ нарт үүрэг болгож, Тагнуулын ерөнхий газрын дарга /хурандаа Д.Гэрэл/ -д зөвлөсүгэй.

